

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/320/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК Гүйцэтгэх захирал,
С.Оюунгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 4/93
танай _____-ны № _____-г

**ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
А.ЭРДЭНЭБАТ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 482,160.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

019020136

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 9,933,096.4 мянган төгрөгийн үнэтэй 920 хүүхдийн багтаамжтай 3 давхар сургуулийн барилгыг хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90,6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>304,119,079.15</u>	<u>684,668,096.76</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	78,166,621.27	482,160,995.35
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	78,166,621.27	482,160,995.35
3121	Төгрөг	78,166,621.27	482,160,995.35
31211	Төрийн сангийн харилцах	78,166,621.27	482,160,995.35
33	АВЛАГА	82,369,870.69	106,908.62
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,512,554.69	106,908.62
35	БАРАА МАТЕРИАЛ	143,582,587.19	202,400,192.79
354	Хангамжийн материал	142,882,587.19	202,400,192.79
35410	Бичиг хэргийн материал	627,504.00	620,715.00
35420	Аж ахуйн материал	1,096,190.00	2,749,500.00
35440	Түлш, шатах тослох материал	1,604,000.00	5,525,000.00
35460	Хүнсний материал	1,453,667.30	4,016,823.90
35470	Бусад хангамжийн материал	138,101,225.89	186,945,153.89
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,634,309,613.49</u>	<u>15,483,701,805.44</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,634,309,613.49	15,483,701,805.44
392	Биет хөрөнгө	5,538,156,144.04	15,387,767,102.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,709,670,801.19	15,642,767,232.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(794,606,337.02)	(1,013,340,861.14)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86,213,654.80	86,213,654.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(19,250,113.14)	(27,812,613.18)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	288,505,474.18	481,915,329.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	(65,910,480.06)	(153,342,902.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	383,622,251.66	485,239,220.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	(90,758,749.84)	(168,140,674.45)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,516,237.00	20,998,025.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(864,614.41)	(3,118,582.62)
39217	Ном	23,018,019.68	36,389,274.98
393	Биет бус хөрөнгө	96,153,469.45	95,934,702.85
39301	Програм хангамж	656,300.00	656,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(18,230.55)	(236,997.15)
39303	Бусад биет бус хөрөнгө	95,515,400.00	95,515,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,938,428,692.64</u>	<u>16,168,369,902.20</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>46,970,898.81</u>	<u>1,881,457.10</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	46,970,898.81	1,881,457.10
413	Өглөг	46,970,898.81	1,881,457.10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	368,902.41
4136	Бусад өглөг	46,970,898.81	1,512,554.69
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,512,554.69	1,512,554.69

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,891,457,793.83</u>	<u>16,166,488,445.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,891,457,793.83	16,166,488,445.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,008,954,216.48	1,008,954,216.48
51101	Өмч: - төрийн	1,008,954,216.48	1,008,954,216.48
512	Хуримтлагдсан үр дүн	2,768,326,638.21	13,043,357,289.48
51210	Өмнөх үеийн үр дүн	2,768,326,638.21	2,768,326,638.21
51220	Тайлант үеийн үр дүн	-	10,275,030,651.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,114,176,939.14	2,114,176,939.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,938,428,692.64</u>	<u>16,168,369,902.20</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,756,344,454.88	13,982,087,700.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,835,873,554.88	10,267,363,900.50
120	Нийтлэг татварын бус орлого	5,835,873,554.88	10,267,363,900.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,835,873,554.88	10,267,363,900.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,463,400.00	299,970.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	34,640,500.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	79,800,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,920,470,900.00	3,714,723,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,355,952,900.00	3,254,435,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,355,952,900.00	3,254,435,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,159,400.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,272,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	887,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	479,358,600.00	460,287,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	479,358,600.00	460,287,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,062,530,492.99	3,707,057,049.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,062,530,492.99	3,707,057,049.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,848,600,892.99	3,498,446,847.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,656,805,216.37	2,050,353,226.07
210101	Үндсэн цалин	1,172,434,641.18	1,402,623,232.79
210102	Нэмэгдэл	419,773,177.29	555,591,471.08
210104	Урамшуулал	64,597,397.90	92,138,522.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,090,557.36	257,886,073.19
210201	Тэтгэврийн даатгал	144,703,714.47	181,612,833.32
210202	Тэтгэмжийн даатгал	16,572,813.88	18,810,213.03

210203	ҮОМШӨ-ний даатгал	13,258,170.85	17,433,979.64
210204	Ажилгүйдлийн даатгал	3,181,712.64	3,615,786.49
210205	Эрүүл мэндийн даатгал	32,374,145.52	36,413,260.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	424,521,454.12	424,714,246.12
210301	Гэрэл, цахилгаан	35,864,587.50	41,918,090.87
210302	Түлш, халаалт	379,266,866.62	371,547,255.25
210303	Цэвэр, бохир ус	9,390,000.00	11,248,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,954,672.00	33,031,599.00
210401	Бичиг хэрэг	2,314,610.00	20,888,699.00
210402	Тээвэр, шатахуун	8,548,480.00	10,345,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	91,582.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,797,650.00
2105	Нормативт зардал	217,006,265.00	246,758,607.88
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	815,000.00	285,000.00
210502	Хоол, хүнс	215,152,565.00	237,612,377.88
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,038,700.00	8,861,230.00
2107	Томилолт, зочны зардал	716,000.00	-
210702	Дотоод албан томилолт	716,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,793,400.00	20,083,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,463,400.00	4,011,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,330,000.00	16,072,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	320,713,328.14	465,619,395.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,411,782.95	37,091,439.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,883,040.00	6,008,546.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	190,418,505.19	422,519,410.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	213,929,600.00	208,610,201.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	213,929,600.00	199,120,740.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	129,657,600.00	154,232,350.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	84,272,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	44,888,390.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	9,489,461.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,489,461.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,693,813,961.89	10,275,030,651.27
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	197,182,345.94	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	197,182,345.94	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	197,182,345.94	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,890,996,307.83	10,275,030,651.27

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,921,934,300.00</u>	<u>3,829,165,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,463,400.00	114,441,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,463,400.00	114,441,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,463,400.00	114,441,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,463,400.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	34,640,500.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	79,800,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,920,470,900.00	3,714,723,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,355,952,900.00	3,254,435,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,355,952,900.00	3,254,435,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,159,400.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,272,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	887,400.00	-
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	479,358,600.00	460,287,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	479,358,600.00	460,287,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,843,667,678.73</u>	<u>3,350,806,625.92</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,843,667,678.73	3,350,806,625.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,598,583,278.73	3,139,694,091.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,656,382,716.37	2,049,919,068.34
210101	Үндсэн цалин	1,135,804,415.24	1,390,076,622.48
210102	Нэмэгдэл	444,686,636.53	567,919,122.66
210104	Урамшуулал	75,891,664.60	91,923,323.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,090,557.36	256,936,369.44
210201	Тэтгэврийн даатгал	144,346,738.59	175,821,169.93
210202	Тэтгэмжийн даатгал	16,572,813.88	20,417,105.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,258,170.85	17,372,792.04
210204	Ажилгүйдлийн даатгал	3,181,712.64	3,921,639.99
210205	Эрүүл мэндийн даатгал	32,731,121.40	39,403,662.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	380,786,700.00	450,018,938.65
210301	Гэрэл, цахилгаан	35,507,742.50	34,375,262.91
210302	Түлш, халаалт	335,532,112.50	401,394,775.74
210303	Цэвэр, бохир ус	9,746,845.00	14,248,900.00
2105	Нормативт зардал	183,338,475.00	239,985,074.48
210502	Хоол, хүнс	183,338,475.00	239,985,074.48
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,500,000.00	779,500.00

210604	Урсгал засвар	3,500,000.00	779,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,793,400.00	20,083,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,463,400.00	4,011,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,330,000.00	16,072,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	156,691,430.00	121,971,440.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	132,054,730.00	96,640,530.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,636,700.00	25,330,910.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	245,084,400.00	211,112,534.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	245,084,400.00	201,623,073.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	160,812,400.00	156,944,224.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	84,272,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	44,678,849.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	9,489,461.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,489,461.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>78,266,621.27</u>	<u>478,358,374.08</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	74,364,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	74,364,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	74,364,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	74,364,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(74,364,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	78,266,621.27	403,994,374.08
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	78,166,621.27
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	78,166,621.27	482,160,995.35

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,008,954,216.48	1,876,911,414.64	2,788,318,495.93	5,674,184,127.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	8,991,465.70	8,991,465.70

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,008,954,216.48	1,876,911,414.64	2,797,309,961.63	5,683,175,592.75
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-9,472,575.06	-9,472,575.06
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,008,954,216.48	2,114,176,939.14	2,768,326,638.21	5,891,457,793.83
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,008,954,216.48	2,114,176,939.14	2,768,326,638.21	5,891,457,793.83
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,008,954,216.48	2,114,176,939.14	2,768,326,638.21	5,891,457,793.83
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,275,030,651.27	10,275,030,651.27
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,008,954,216.48	2,114,176,939.14	13,043,357,289.48	16,166,488,445.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		78,166,621.27	(78,166,621.27)	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,909,397,700.00	3,415,681,164.58	493,716,535.42	87.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,909,397,700.00	3,415,681,164.58	493,716,535.42	87.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,675,958,800.00	3,214,058,091.58	461,900,708.42	87.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,406,334,800.00	2,049,919,068.34	356,415,731.66	85.19
210101	Үндсэн цалин	1,620,568,400.00	1,390,076,622.48	230,491,777.52	85.78
210102	Нэмэгдэл	674,228,500.00	567,919,122.66	106,309,377.34	84.23
210104	Урамшуулал	111,537,900.00	91,923,323.20	19,614,576.80	82.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	300,791,600.00	256,936,369.44	43,855,230.56	85.42
210201	Тэтгэврийн даатгал	204,538,200.00	175,821,169.93	28,717,030.07	85.96
210202	Тэтгэмжийн даатгал	24,063,300.00	20,417,105.40	3,646,194.60	84.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,250,600.00	17,372,792.04	1,877,807.96	90.25
210204	Ажилгүйдлийн даатгал	4,812,800.00	3,921,639.99	891,160.01	81.48
210205	Эрүүл мэндийн даатгал	48,126,700.00	39,403,662.08	8,723,037.92	81.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	459,455,100.00	450,018,938.65	9,436,161.35	97.95
210301	Гэрэл, цахилгаан	34,456,200.00	34,375,262.91	80,937.09	99.77
210302	Түлш, халаалт	407,819,400.00	401,394,775.74	6,424,624.26	98.42
210303	Цэвэр, бохир ус	17,179,500.00	14,248,900.00	2,930,600.00	82.94
2105	Нормативт зардал	267,100,800.00	239,985,074.48	27,115,725.52	89.85

210502	Хоол, хүнс	267,100,800.00	239,985,074.48	27,115,725.52	89.85
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	779,500.00	720,500.00	51.97
210604	Урсгал засвар	1,500,000.00	779,500.00	720,500.00	51.97
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,195,500.00	20,083,700.00	1,111,800.00	94.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,011,300.00	4,011,300.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,184,200.00	16,072,400.00	1,111,800.00	93.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	219,581,000.00	196,335,440.67	23,245,559.33	89.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	193,804,700.00	170,559,530.67	23,245,169.33	88.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,776,300.00	25,775,910.00	390.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	233,438,900.00	201,623,073.00	31,815,827.00	86.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	233,438,900.00	201,623,073.00	31,815,827.00	86.37
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	188,760,000.00	156,944,224.00	31,815,776.00	83.14
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44,678,900.00	44,678,849.00	51.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,909,397,700.00	3,829,165,000.00	80,232,700.00	97.95
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,334,236,600.00	3,254,435,900.00	79,800,700.00	97.61
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,334,236,600.00	3,254,435,900.00	79,800,700.00	97.61
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	460,955,100.00	460,287,900.00	667,200.00	99.86
132001	Орон нутгийн төсвөөс	460,955,100.00	460,287,900.00	667,200.00	99.86
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			-	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	114,206,000.00	114,441,200.00	(235,200.00)	100.21
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	36,141,200.00	34,640,500.00	1,500,700.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	78,064,800.00	79,800,700.00	(1,735,900.00)	102.22
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	78,166,621.27	(78,166,621.27)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	483,073,338.34	(483,073,338.34)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	125.00	125.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	77.00	77.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	47.00	47.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,584.00	1,564.00	20.00	98.74
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,584.00	1,564.00	20.00	98.74
630001	Төрийн өмчит ЕБС	1,584.00	1,564.00	20.00	98.74
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	125.00	125.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	125.00	125.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023-2024 оны хичээлийн жилд “Эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх” зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Монгол Улсын бага, дунд боловсролын тухай хуульд бага, суурь, бүрэн дунд боловсролын зорилтыг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай Монгол хүүхэд төлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх гэж тодорхойлсон.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамрах албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 376,471.0 мянган төгрөгөөр буюу 3,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	78,166.6	482,161.0	403,994.4
Авлага	82,369.9	106.9	(82,263.0)
Бараа материал	143,582.6	202,400.2	58,817.6
Үндсэн хөрөнгө	5,634,309.6	15,483,701.8	9,849,392.2
Нийт хөрөнгө	5,938,428.7	16,168,369.9	10,229,941.2
Богино хугацаат өр төлбөр	46,970.9	1,881.5	(45,089.4)
Засгийн газрын хувь оролцоо	1,008,954.2	1,008,954.2	0.0

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,114,176.9	2,114,176.9	0.0
Хуримтлагдсан үр дүн	2,768,326.6	13,043,357.3	10,275,030.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,938,428.7	16,168,369.9	10,229,941.2

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Мөнгөн хөрөнгийн данс 403,994.4 мянган төгрөгөөр өссөн нь батлагдсан санхүүжилтээс цалингийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Авлагын данс 82,263 мянган төгрөгөөр буурсан нь санхүүжилттэй холбоотой авлагаа авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 58,817.6 мянган төгрөгөөр өссөн нь сургуулийн 100 жилийн ойн арга хэмжээтэй холбоотойгоор төгсөгчид болон эцэг эхчүүдийн хандиваар нийт 36,080.6 мянган төгрөгийн бараа материалын орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 9,849,392.2 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 9,933,096.4 мянган төгрөгийн үнэтэй 920 хүүхдийн багтаамжтай 3 давхар сургуулийн барилгыг хүлээн авч бүртгэлд тусгасантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,593,805.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой зардлыг тус тус өсгөж 3,909,592.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн төслийг өсгөсөн нь албан хаагчдын цалинд 2023 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс цалин нэмэгдсэн, байр ашиглалтын зардлын дүн өссөн зэрэг өөрчлөлт орсноос шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 315,592.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг

санхүүжүүлэхээр улсын төсвөөс 3,909,397.7 мянган төгрөгийг олгохоор баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,254,435.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 34,640.5 мянган төгрөг, өмнө оны санхүүжилтийн үлдэгдэл 79,800.7 мянган төгрөг, орон нутгийн санхүүжилт 460,287.9 мянган төгрөгийн орлого тус тус төвлөрүүлж урсгал үйл ажиллагаанд 3,415,681.2 мянган төгрөг буюу 87,4 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
Д/А	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	80217 Мэдээлэл технологийн үйлчилгээ	5,615.10	-	5,615.10	-
2	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	2,052.10	2,052.10	-	100.00
3	80233 Хүүхэд хамгаалал	1,531.40	1,531.40	-	100.00
4	80304 Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	-	
5	80312 Сургалт семинар	-	437.00	(437.00)	
6	81605 Эрүүл мэндийг дэмжих	-	73.70	(73.70)	
7	81801 Үдийн цай хөтөлбөр	26,511.00	26,511.00	-	100.00
8	81806 Дотуур байрны үйлчилгээ	176,478.20	176,478.20	-	100.00
9	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	-	-	-	
10	81823 Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	2,812.40	2,812.40	-	100.00
11	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	-	-	-	
12	81834 Боловсролын стандарт, сургалтын	400,011.00	400,011.00	-	100.00
13	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	-	-	-	
14	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	-	-	-	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилт аваагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ын аудитор Б.Дашням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны хагас жилийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 788,862.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 11,832.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн 2023 он үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,707,057.0 мянган төгрөгийн 1,5 хувиас 75 хувиар тооцож 41,704.4 мянган төгрөг гэж шинэчлэн тооцлоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 159 мэдээллээс 144 мэдээллийг хугацаанд нь байршуулж 6 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй 262,065.2 мянган төгрөгийн гүйлгээг оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв орхигдуулсан зүйлгүй оруулдаг байх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Засгийн газрын хувь оролцоо санхүүгийн тайлангаар 1,008,954.2 мянган төгрөг, байгууллагын гэрчилгээгээр 164,884.0 төгрөг байгаа нь санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ буюу үйл явдал, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үнэн зөв баталгаажуулах, бүртгэлдээ өөрчлөлтийг оруулах зөвлөмж хүргүүлэв.

2. Сургуулийн 920 хүүхдийн 3 давхар 9,933,096.4 мянган төгрөгийн үнэтэй сургуулийн барилгыг шинээр орлогод хүлээн авсан боловч уг барилгын хана цуурсан, халаалт дулаан хэвийн биш, шал пөмбийсөн, өрөө бүрийн хэсэгт цуурсан зэрэг ашиглалтын шаардлага хангахгүй байдалтай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 10.1.11.төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах; гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Барилгын бүх засвар үйлчилгээг барьсан байгууллагаар хийлгэж барилгын ашиглалттай холбоотой зөрчлийг арилгуулах зөвлөмж хүргүүлэв.

3. Санхүүгийн тайланг аудитын байгууллагад 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр хугацаа хоцроож ирүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 8.9.1.төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж, дээд шатны байгууллагад хүргүүлдэг байх зөвлөмж хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шилэн данс, анхан шатны баримт, тайлагнал, цалингийн данстай холбоотой 4 зөвлөмж хүргүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул гүйцэтгэлээр дахин хянаж үзэв.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16,027.6 мянган төгрөгийн 6 зөрчил илэрч 3 зөвлөмж, 3 акт өгсөн байна биелэлт 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	11,885.7	3	11,885.7	100
Акт	3	4,141.9	3	4,141.9	100
Нийт дүн	6	16,027.6	6	16,027.6	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал төсөв, санхүүжилтийг үндэслэлтэй баталдаг байх, төрийн чиг үүргийг хангалттай хэрэгжүүлэн ажиллах талаар анхаарал хандуулах болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,021.8 мянган төгрөгийн алдаа зөрчил¹ илэрч 14,021.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өглөгийн талаар холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд нийт 106.9 мянган төгрөгийн авлага, 1,881.4 мянган төгрөгийн өглөгтэй гарсан, 2017-2023 онд зам ашиглалтын өглөг, газрын төлбөрийн өглөг 1,064.3 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж тулган баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гаргахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах, аудитын батламж мэдэгдлийн оршин байх "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж байгууллагад бодитой оршин байх", эрх ба үүрэг "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өглөг уг аж ахуй нэгж байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх" гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж : Авлага, өглөгийг бүрэн барагдуулах арга хэмжээг авч ажиллах.

2. Анхан шатны баримтын талаар холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн түүврээр Цахим баримтын бүрдэлд 4,517.9 мянган төгрөгийн зөрүүтэй гүйлгээ гарсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." Гэсэн заалтуудтай зөрчилдөж байна

Өгсөн зөвлөмж: Цахим баримтын бүрдэлтэд хяналт тавьж ажиллах илүү, дутуу баримт гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

2. Цалингийн данстай холбоотой асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Татварын тайлангаар хувь хүний орлогын албан татварын өглөг 160,690.0 мянган төгрөг, харилцахаар тушаасан дүн 155,205.4 мянган төгрөг буюу 5,484.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх;" санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ буюу үйл явдал, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн байх гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүү, татварын тайланг үнэн зөв тооцооллын алдаагүй бэлтгэдэг байх зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймгийн төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Татвар, санхүүгийн тайланг тооцооллын алдаатай зөрүүтэй гаргасан.	1	5,484.6										1	5,484.6
Дүн	1	5,484.6										1	5,484.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийн түүврээр Цахим баримтын бүрдэлд 5,484.6 мянган төгрөгийн зөрүүтэй гүйлгээ гарсан байгаа	1	5,484.6					1	5,484.6				
Тайлант онд авлага өглөгтэй гарсан, тооцоо нийлээгүй байна.	1	3,052.6					1	3,052.6				
Дүн	2	8,537.2					2	8,537.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй гүйлгээг дутуу оруулсан байна.	1	262,065.2				1	262,065.2
Дүн	1	262,065.2				1	262,065.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Засгийн газрын хувь оролцоо санхүүгийн тайлангаар 1,008,954.2 мянган төгрөг, байгууллагын гэрчилгээгээр 164,884.0 төгрөг байна.	1					1	
Сургуулийн 920 хүүхдийн 3 давхар 9,933,096.4 мянган төгрөгийн үнэтэй сургуулийн барилгыг шинээр орлогод хүлээн авсан боловч уг барилгын хана цуурсан, халаалт дулаан хэвийн биш, шал пөмбийсөн, өрөө бүрийн хэсэгт цуурсан зэрэг ашиглалтын шаардлага хангахгүй байдалтай байна.	1					1	
Хуулийн хугацаанд аудитын байгууллагад санхүүгийн тайлан ирүүлээгүй.	1					1	
Дүн	3					3	
Нийт дүн	4					4	